



**УВС АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

85165, Улаангом, Увс аймаг
Утас/ Факс: (01452) 7045-2012
E-mail: info@uvs.gov.mn

2020.02.10 № 5/189

танай _____-ны № _____-т


┌ **ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН** ┐
ДАРГА Б.БАЯРСАЙХАН ТАНАА

Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал “Алсын хараа – 2050” бодлогын баримт бичиг болон “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар” төслийг судалж танилцах ажлыг тус аймагт зохион байгуулж байна. Саяхан бүх сумдын удирдлагууд, аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, Тогтвортой хөгжил-Түншлэлийн зөвлөлийн гишүүдийг оролцуулан, төслийн танилцуулга хийж, санал солилцох хэлэлцүүлэг өрнүүллээ.

Эхний хэлэлцүүлгээс гарсан саналыг товчоолж хавсралтаар хүргүүлэв. Мөн 2019 оны 5-р сард хуралдсан аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцэж баталсан “Увс аймгийн хөгжлийн хэтийн зорилт” бодлогын баримт бичгийн номыг хүргүүлээ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,
АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ

Б.БАТ-ЕРӨӨЛТ



D:\A3ДТГ\tamga-A5.DOC
8520020223

УВС АЙМАГ
“Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын төсөлд нэмэрлэх
урьдчилсан саналууд

2020.01.28

1. Төсөлд “Өрнөд Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, Алтайн соёл, Байгалийн нөөц, ногоон хөгжлийн бүс”-д баруун 3 аймаг, Ховд, Увс, Баян-Өлгийг хамруулсан нь зөв. Эндээ мээо, микро бүсүүдийн төвүүдийг улс, бүсийн чанартай авто замын сүлжээтэй холбож, тээвэр логистикийн төвүүдийг байгуулах зорилгод “Увс – Ховд аймаг” чиглэлийн авто замыг барих асуудлыг 1-р үе шатанд буюу 2021-2024 онуудад баруулахаар тусгах /Учир нь: Авто замын зураг төсөв нь хийгдсэн, ЗТХЯ-д байгаа, АХБ-ны зүгээс ч судалгаа хийгдсэн/
2. Мөн энэ жилээс Боршоо боомтыг олон улсын статустай болгож, нэвтрэх чадварыг нэмэгдүүлэн, боомтын цогцолборыг шинэчлэх ажлыг АХБ-ны дэмжлэгээр эхлүүлэхээр ТЭЗҮ, зураг төсвийг бэлэн болгосон тул ойрын жилүүдийн үйл ажиллагаанд оруулж төлөвлөх
3. “Өндөр уулын экосистемд зохицсон мал аж ахуй эрхэлж, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх” зорилтын үйл ажиллагаа хэсэгт 3 аймгийн онцлогийг тодорхой зааж өгөх, өөдөр хэлбэл Увс аймагт өндөр уулын бүсэд зохицсон “САРЛА”-ийг үржүүлэх, улмаар сарлагийн тослог ихтэй сүү, мах, хөөвөр зэрэг түүхий эдийг боловсруулах, агро паркийн зохион байгуулалтаар кластержүүлж хөгжүүлэх, Улаангомын орчинд малчид, фермерүүдийн бүтээгдэхүүн худалдан борлуулах сүлжээг байгуулах зорилтыг тусгах
4. Өрнөдийн бүс дотроо эдийн засгийн мээо /том/, микро /жижит/ төвүүдийн тээвэр логистикийн төв барих гэдгийг тодорхой болгож, аймаг бүрээс нэрчилж оруулах, ялангуяа ОХУ талдаа Тывагийн Хандагайтын боомт чиглэлд олон улсын тээвэр логистикийн зориулалтаар авто замаа шинэчилж тавьсантай уялдуулж, Боршоод эдийн засгийн чөлөөт бүс, Улаангомад ачаа тээврийн терминал аж ахуй, логистикийн төвийг хамтран байгуулах асуудлыг хэрэгжүүлэхийг дэмжих
5. Төслийн 8.13-т аймгуудын микро бүсийн төвүүдийг тогтоохдоо аймгуудтай сайтар зөвшилцөх нь чухал. Жишээ нь Увсад хантайн 3 сумыг /Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан/ баруунтруун төвтэй байх нь хэр оновчтой вэ? Манай аймгийн дотоодын бүсчлэлээр баруунтруун сум нь зүүн бүсийн төв бөгөөд газар тариалангийн үндсэн бүс, үйлдвэрлэлийн төв гэж төлөвлөгдөж байгаа. Зарим сумыг бүсийн микро төв гэхээсээ илүү хот хоорондын авто зам дагуух /Наранбулаг, Зүүнхангай, Саян... г.м./ тээвэр логистикийн дагуул, үйлдвэрлэл үйлчилгээний төв, ХАА-н болон кластерийн төв /Улаангом, Өмнөговь, Тариалан/... гэх мэтээр эдийн засгийн ирээдүй бүхий төслөөр нь авч үзэмээр байна.
6. Увсад чацаргана, жимс жимсгэний кластерыг дагнан хөгжүүлэх асуудлыг оруулах үндэслэл байгааг анхаарах, зэрэг зарчмын саналуудыг эхний удаад уламжилж байна.

Увс аймагт болсон “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын хэлэлцүүлэгт аймгийн засаг дарга Д.Батсайханы онцолж хэлсэн үгнээс...

2019.06.17

Тэрээр хэлсэн үгэндээ:Увс аймаг дэлхийн өв өлгий нутаг. Аялал жуулчлалын салбарыг үндсэн бодлого болгон 3 жил тодорхой ажлууд төлөвлөн хийж ирлээ.

Манай аймагт уул уурхай хөгжихөд дэд бүтэц хангалттай биш байна. Хууль эрх зүйн орчин сайн биш. Байгаль экологийн бүтэц эмзэг, олон ус нууруудтай. Нөөц бололцоонд тулгуурлаж аялал жуулчлалын салбрыг хөгжүүлбэл зүгээр гэж бодож төлөвлөж ажиллаж байгаа. Жил бүр зохион байгуулдаг аялал жуулчлалын үзэсгэлэнд 3 дахь жилдээ зохион байгуулалттай оролцсон. Энэ жил Увс аймаг Үзэсгэлэнгийн Түнш аймгаар хамтран зохион байгуулсан.

5 сарын 29-ний аймгийн хуралдаанаар аймгийн хөгжлийн чиг хандлага, хэтийн зорилт бодлогын баримт бичгийг баталсан. Сонгон шалгаруулалт зарлаж эрдэмтэн докторуудын багийг шалгаруулаад хийлгэсэн. 4 сарын 6-нд УБ хотод Увсад хөрөнгө оруулагчдын Чуулганыг зохион байгууллаа. АХБанкны төсөл 2020-2028 оны хооронд хэрэгжихээр судалгаа хийгдэж байна. 4 аймагт хэрэгжинэ. Малын өвчнөөс ангид тайван аймаг. 3,2 сая толгой малтай.

Газар тариалангийн салбарын хувьд усалгаатай тариаланг дэмжиж хөгжүүлсэн аймаг. Усалгаатай газар тариаланг хослуулан хөгжүүлэх, царгасыг дээр үеэс эхэлж тарьж байсан. Анх 1905 онд тарьж байсан.

ОХУ-тай шууд хиллэдэг. Баруун бүсийн хөгжлийн коридорыг тогтоогоод тээвэр ложистикийн төвийг бий болгох зорилт тавьж байна. Тувагийн ЗГ-аас Увс, Ховд аймгийн чиглэлд Хятадтай авто замаар холбох хэрэгтэй гэж ярьж байгаа. 6 сарын 28-нд ОХУ-ын Тувад олон улсын түвшинд хэлэлцүүлэг хийх тухай санал ирсэн байгаа. Бид оролцож, холбогдох гэрээ, санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулах болно. Босоо тэнхлэгийн замыг хийх ёстой гэж бодож байгаа.

Газар тариалангийн бүс дээр Увс аймаг тодорхой хэмжээний амжилт гаргасан гэж үзэж байгаа. Баруун 5 аймгийн хэрэгцээг малын тэжээлээр, гурилаар хангадаг үйлдвэр ажиллаж байсан. 2018 онд 25 жилийн дараа газар тариалангийн салбар нэмэгдэх хандлагатай болсон. 1990-ээд оны эдийн засгийн хэмжээнд хүрэхээр зорьж ажиллаж, хөөцөлдөж байна.

Аялал жуулчлал дээр ГХАН-эс тодорхой төсөл хэрэгжиж байгаа. Бүс нутгийн аялал жуулчлал, хил орчмын аялал жуулчлалыг олж харсан. Өнгөрсөн жил гэхэд 80 гаруй мянган иргэн Боршоогийн боомтоор орж гарсан мэдээтэй. Энэ нь цаанаа аймгийн эдийн засгийн хөгжилд нэмэр болж байгаа. Алтайн Байгалийн нөөц газарт жилд сая орчим жуулчин цаанаас ирдэг. Дор хаяж 200 мянган жуулчин манай аймаг, Баян-өлгийд аялах боломж байгаа. Хятад, солонгос, тайваны жуулчид Увс руу ирдэг. Мөн дотоодын жуулчдын урсгал ч манайх руу чиглэсэн байна.

ЗГ-аас Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор АХБанктай гэрээ хийж байна лээ. Нисэх онгоцны буудлыг ОУ-ын нислэгтэй болгох хэрэгтэй байна. **ҮХГ-аас 2023 он гэж тавьсан. Энэ хугацааг наашлуулмаар байна.**

Боршоогийн боомтыг ОУ-ын болгохоор зураг төсөв хийгдсэн. Сангийн Яамны хөгжлийн хөтөч төслийн багтай хамтран ажиллаж байна. ОХУ-аас Хандгайтын боомтыг ОУ-ын статустай болгох тухай шийдвэр гарсан байдаг. 15 жилийн өмнө ОХУ-н ерөнхийлөгч Тувад айлчилж байхдаа төмөр зам тавина, гэж шав тавьсан байдаг.

Увс аймгийн хамгийн том хөгжлийн коридор бол Ховдоос Хятад улс руу мөн ОХУ-ын хил хүртэл тавьж байгаа зам байгаа. Энэ 2 зам тавигдчихвал баруун бүс нутгийн болон Увс аймгийн хөгжилд маш томоохон ач холбогдолтой болно, гэдгийг онцлов.

Увс аймагт эхний ээлжинд анхаарч шийдвэрлэх асуудлууд:

2020.01.20

1. ТОСК-ийн хөрөнгө оруулалтаар орон сууцнуудыг үргэлжлүүлж барих

Улаангомд ТОСК-ийн хөрөнгө оруулалтаар 2014-2015 онуудад баригдсан 105 айлын 3 орон сууц нь түрээсийн орон сууцны зориулалтаар ашиглагддаг.

Сүүлийн 3 жилд Улаангомд 200 гаруй айлын нийтийн орон сууц баригдан ашиглалтанд орсон бөгөөд борлуулалт нь 100 хувьтай байна. Эндээс харахад орон сууцны эрэлт хэрэгцээ тус аймагт ойрын жилүүдэд хангалттай түвшинд байх нь тодорхой тул ТОСК-ийн сууцнуудыг үргэлжлүүлж барих, эсвэл түрээсийн орон сууцны эрхийг аймагт шилжүүлэх

2. Орон сууцны ипотекийн зээл олголтыг нэмэгдүүлэх

Манай аймагт 2008 оноос хойш 40,0 гаруй тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 963 иргэнд олгосон байдаг. Сүүлийн жилүүдэд жилд 100 гаруй айлын орон сууц баригдаж ашиглалтанд ороход борлуулалт 100 хувь, банкуудад жилдээ 400 гаруй иргэн ипотекийн зээлд хамрагдахаар хүсэлт гаргаж байгаагаас харахад цаашид түрээсийн болон бусад орон сууцнуудаар иргэдийг хангах шаардлага байгаа нь харагдаж байна. Иймд орон сууцны борлуулалтын байдал, эрэлт, хэрэгцээ шаардлагыг үндэслэн манай аймагт хуваарилагддаг ипотекийн зээлийн хэмжээг нэмэгдүүлэх

3. ЖДҮ-ийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх

Тус аймагт сүүлийн 3 жилд зээлийн эх үүсвэр ЖДҮДС-аас ирээгүй, эрэлт хүсэлт их байгаа. 2019 онд 1.0 тэрбум төгрөгний зээлийн эх үүсвэр нээгдэж, 15 төслийг 860-аад сая төгрөгөөр дэмжсэн. Цаана нь хөрөнгө оруулалт хүссэн, ажлын байр бий болгох, нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготой олон томоохон төсөл бэлэн байна. Үүнийг харгалзан үзэж, зээлийн эх үүсвэрийг дахин үргэлжлүүлэх шаардлагатай байна.

4. Хүнсний худалдааны төв байгуулах

Тус аймгийн төвд ажилладаг бараа, хүнсний бараа бүтээгдэхүүний захад худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн ажиллах орчныг сайжруулах асуудал аймгийн хөгжлийн үндсэн чиглэлд тусгагдаж, Засгийн газрын дэмжлэгтэйгээр үе шаттай шийдвэрлэж байна. 2013-2014 онд Засгийн газрын 3.0 тэрбум төгрөгний дэмжлэгээр Улаангом захын барааны хэсэгт битүү зах – “Худалдааны төв” баригдаж, бизнес эрхлэгч, худалдаачид, хэрэглэгчдийн үйлчилгээний орчин нөхцөл өдрөөс өдөрт сайжирсаар байна. Тэгвэл одоо захын Хүнсний хэсгийн хойт хэсэгт байгаа газрыг ашиглан, Хүнсний битүү зах буюу “Хүнсний худалдааны иж бүрэн төв” байгуулах санал, хүсэлтийг иргэд, хэрэглэгчид, бизнес эрхлэгчид тавьж байна. Газрын асуудлыг шийдэх боломжтой.

5. Улаангомдын төв Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх

Шинэчлэх зураг, төсөв хийгдсэн. Олон эх үүсвэр яригдсан ч өнөөг хүртэл шийдэгдээгүй байна. Иргэдийн саналаар эрэмблэгдсэн ажлын нэг.

6. ХАА-н кластер, агропарк, бизнес худалдааны сүлжээ байгуулах

Аймгийн төв-Улаангомын орчинд мах, сүүний фермерүүдийг дэмжиж, кластеруудыг бий болгох, малын тэжээлийн үйлдвэр, ХАА-н эко бүтээгдэхүүний үйлдвэр-агро парк, борлуулалтын сүлжээ байгуулах

Саналыг нэгтгэж томъёолсон: ХОХБТХ-ийн ахлах З.Ганболд

Хянасан: ХОХБТХ-ийн дарга Б.Бат-Ерөөлт